

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/262-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn
---------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	18-21
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18-19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОТГОНТУЯА ТАНАА

2023.02.25 № СГА-2023/262 НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар томилолтын зардлыг илүү тооцож олгосон, төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн, төсвийн хөрөнгийн үр ашигтай, арвилан хэмнэлттэй байх зарчмыг алдагдуулж унаа, хоолны хөнгөлөлтийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, хүчин төгөлдөр бус болон бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.10, 8.2, 8.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газар нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 75.5 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 24.5 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 77.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой зардалд 10,144.2 мянган төгрөгийг, хангамж, бараа материалын зардалд 5,946.6 мянган төгрөгийг, эд хогшил, урсгал засварын зардалд 9,959.6 мянган төгрөгийг, дотоод албан томилолтын зардалд 1,000.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 4,013.4 мянган төгрөгийг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 1,386.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0	10,200,665.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	40,589.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	0	40,589.00
31210	Төгрөг	0	40,589.00
31216	Арилжааны банк дахь харилцах данс	0	40,589.00
33	АВЛАГА	0	290,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	290,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0	9,870,076.00
35400	Хангамжийн материал	0	9,870,076.00
35410	Бичиг хэргийн материал	0	1,380,300.00
35420	Аж ахуйн материал	0	5,442,600.00
35470	Бусад хангамжийн материал	0	3,047,176.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	47,615,088.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0	47,615,088.55
39200	Биет хөрөнгө	0	46,115,088.55
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0	29,787,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0	(3,491,570.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0	19,911,301.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0	(92,242.38)
39300	Биет бус хөрөнгө	0	1,500,000.00
39301	Програм хангамж	0	1,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0	57,815,753.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	2,141,471.06
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	2,141,471.06
41300	Өглөг	0	2,141,471.06
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	747,211.06
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	1,394,260.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0	55,674,282.49
51	Засгийн газрын хувь оролцоо	0	55,674,282.49
51200	Хуримтлагдсан үр дүн	0	55,674,282.49
51220	Тайлант үеийн үр дүн	0	55,674,282.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0	57,815,753.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0	323,123,501.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	9,667,301.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	9,667,301.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	9,667,301.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0	313,456,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	211,641,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	211,641,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	101,814,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	62,214,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	39,600,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0	267,449,218.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	267,449,218.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	203,603,071.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	109,825,151.13
210101	Үндсэн цалин	0	84,458,175.47
210102	Нэмэгдэл	0	10,081,498.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	11,650,000.00
210104	Урамшуулал	0	3,635,477.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	13,963,155.12
210201	Тэтгэврийн даатгал	0	9,557,702.12
210202	Тэтгэмжийн даатгал	0	1,108,047.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	886,438.01
210204	Ажилгүйдлийн даатгал	0	194,872.29
210205	Эрүүл мэндийн даатгал	0	2,216,095.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	10,144,200.00
210301	Гэрэл, цахилгаан	0	653,932.00
210302	Түлш, халаалт	0	8,542,268.00
210303	Цэвэр, бохир ус	0	948,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	29,129,429.00
210401	Бичиг хэрэг	0	738,810.00
210402	Тээвэр, шатахуун	0	10,877,627.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	453,592.00
210404	Ном, хэвлэл	0	15,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	1,309,400.00
2105	Нормативт зардал	0	3,991,000.00
210502	Хоол, хүнс	0	3,991,000.00
2107	Томилолт, зочны зардал	0	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	0	1,000,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	12,583,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	12,363,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	22,966,736.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	19,382,924.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0	3,583,812.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	63,846,146.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	1,386,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,386,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	62,460,146.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	51,847,262.81
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	10,612,884.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0	55,674,282.49
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0	55,674,282.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0	313,456,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0	313,456,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	211,641,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	211,641,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	101,814,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	62,214,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	39,600,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	303,456,011.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	303,456,011.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	239,609,864.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	109,161,248.09
210101	Үндсэн цалин	0	84,594,220.00
210102	Нэмэгдэл	0	9,461,551.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	11,470,000.00
210104	Урамшуулал	0	3,635,477.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	14,169,847.10
210201	Тэтгэврийн даатгал	0	9,764,394.10
210202	Тэтгэмжийн даатгал	0	1,108,047.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	886,438.01
210204	Ажилгүйдлийн даатгал	0	194,872.29
210205	Эрүүл мэндийн даатгал	0	2,216,095.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0	10,144,200.00

210301	Гэрэл, цахилгаан	0	653,932.00
210302	Түлш, халаалт	0	8,542,268.00
210303	Цэвэр, бохир ус	0	948,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0	34,700,158.00
210401	Бичиг хэрэг	0	898,800.00
210402	Тээвэр, шатахуун	0	8,106,716.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	453,592.00
210404	Ном, хэвлэл	0	20,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	4,741,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	30,270,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	14,270,000.00
210602	Тавилга	0	16,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	0	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	0	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	9,333,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	9,113,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	30,831,011.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	30,831,011.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	63,846,146.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	1,386,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	1,386,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	62,460,146.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	51,847,262.81
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	10,612,884.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	10,000,189.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	9,959,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	9,959,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	9,959,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	9,959,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	(9,959,600.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	40,589.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	40,589.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	0	0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	55,674,282.49	55,674,282.49
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	55,674,282.49	55,674,282.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	211,641,600.00	159,794,337.19	51,847,262.81	75.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	211,641,600.00	159,794,337.19	51,847,262.81	75.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,255,600.00	158,408,337.19	51,847,262.81	75.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,197,400.00	109,161,248.09	44,036,151.91	71.26
210101	Үндсэн цалин	101,036,800.00	84,594,220.00	16,442,580.00	83.73
210102	Нэмэгдэл	38,300,000.00	9,461,551.09	28,838,448.91	24.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000.00	11,470,000.00	1,730,000.00	86.89
210104	Урамшуулал	660,600.00	3,635,477.00	(2,974,877.00)	550.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,174,700.00	14,169,847.10	7,004,852.90	66.92
210201	Тэтгэврийн даатгал	14,398,800.00	9,764,394.10	4,634,405.90	67.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,694,000.00	1,108,047.56	585,952.44	65.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,355,200.00	886,438.01	468,761.99	65.41
210204	Ажилгүйдлийн даатгал	338,800.00	194,872.29	143,927.71	57.52
210205	Эрүүл мэндийн даатгал	3,387,900.00	2,216,095.14	1,171,804.86	65.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,144,200.00	10,144,200.00	0.00	100.00

210301	Гэрэл, цахилгаан	480,000.00	653,932.00	(173,932.00)	136.24
210302	Түлш, халаалт	2,332,100.00	8,542,268.00	(6,210,168.00)	366.29
210303	Цэвэр, бохир ус	948,000.00	948,000.00	0.00	100.00
210304	Байрны түрээс	6,384,100.00	0	6,384,100.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,712,500.00	5,946,642.00	765,858.00	88.59
210401	Бичиг хэрэг	1,481,000.00	813,000.00	668,000.00	54.90
210402	Тээвэр, шатахуун	1,204,000.00	1,204,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	642,200.00	453,592.00	188,608.00	70.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,500.00	0	144,500.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,240,800.00	3,476,050.00	(235,250.00)	107.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,959,600.00	40,400.00	99.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,959,600.00	40,400.00	99.19
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,013,400.00	4,013,400.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,013,400.00	4,013,400.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,013,400.00	4,013,400.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,013,400.00	4,013,400.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,386,000.00	1,386,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,386,000.00	1,386,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,386,000.00	1,386,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	211,641,600.00	159,794,337.19	51,847,262.81	75.50
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	211,641,600.00	159,794,337.19	51,847,262.81	75.50
310001	Улсын төсвөөс санхүүжих	211,641,600.00	159,794,337.19	51,847,262.81	75.50
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	11	11	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11	11	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Мөнгөн дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,774,011.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,774,011.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,161,127.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,753,516.00
210401	Бичиг хэрэг	85,800.00
210402	Тээвэр, шатахуун	6,902,716.00
210404	Ном, хэвлэл	20,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,265,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,270,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,270,000.00
210602	Тавилга	16,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,320,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,817,611.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,817,611.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,612,884.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,612,884.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,814,600.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,214,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,600,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	40,589.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,589.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газар /цаашид Соёл, урлагийн газар гэх/ нь “Орон нутгийн түвшинд үндэсний бахархал, эх хэл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, эх оронч, оюунлаг, бүтээлч монгол хүнийг хөгжүүлнэ.” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин


Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д соёлын үйл ажиллагааг дэмжих хүрээнд тус газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёл, урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Соёлын байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу төрөөс санхүүжүүлэх, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийн соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих,
- Соёлын статистик мэдээлэл, соёлын байгууллагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох” тухай 107 дугаар тогтоолоор цалингийн сүлжээнд өөрчлөлт орсныг дагаж мөрдсөн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.



Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, урлагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Соёл, урлагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 57,815.7 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	40.6	40.6
Авлага	-	290.0	290.0
Бараа материал	-	9,870.0	9,870.0
Үндсэн хөрөнгө	-	47,615.1	47,615.1
Нийт хөрөнгө	-	57,815.7	57,815.7
Өр төлбөр	-	2,141.5	2,141.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	55,674.2	55,674.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	57,815.7	57,815.7

Мөнгөн хөрөнгө данс 40.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь соёлын биет бус өвийн “Нүүдэлчин Монгол 2022” их наадмын зардлын зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлага данс нь цалингийн авлагаас шалтгаалан 290.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 24,644.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 14,774.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас бараа материал данс 9,870.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 51,198.9 мянган төгрөгөөр тайлагнагдсан нь төсвийн хөрөнгөөр 21,251.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж /12,229.9 мянган төгрөгийн үнэтэй суурин компьютер 5 ширхэг, 2,441.8 мянган төгрөгийн үнэтэй принтер 4 ширхэг, 2,820.0 мянган төгрөгийн үнэтэй ухаалаг зурагт, 2,500.0 мянган төгрөгийн үнэтэй зөөврийн компьютер, 699.9 мянган төгрөгийн үнэтэй плитка, 559.9 мянган төгрөгийн үнэтэй хөргөгч /, 18,780.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 1,500.0 мянган төгрөгийн үнэтэй “Динамик” санхүүгийн программ худалдан авсан болон Соёлын яамнаас 8,536.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,131.3 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 55,674.2 мянган төгрөг байгаа нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Соёл, урлагийн газрын 2022 оны зардлыг улсын төсвөөс 211,939.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр анх баталсан бол тайлант оны 12 дугаар сард батлагдсан төсөвт дараах байдлаар зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 82.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Хангамж, бараа материалын зардлыг 4,081.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Томлолт зочны зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 986.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 15,539.4 мянган төгрөгөөр бууруулж,
- Байр ашиглалттай холбоотой зардлыг 531.9 мянган төгрөгөөр бууруулж,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 188.7 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 188.7 мянган төгрөгөөр бууруулж гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Ингэснээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 211,641.6 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 211,641.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 159,794.3 мянган төгрөг буюу 75.5 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 44,036.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 7,004.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 765.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 40.4 мянган төгрөгөөр гэх мэт батлагдсан төсвийг нийт **51,847.3** мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	210,255.6	158,408.3	51,847.3	75.3
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,386.0	1,386.0	-	100.0
	Нийт	211,641.6	159,794.3	51,847.3	75.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв


Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Соёлын сайдын А/212 дугаар тушаалаар 20,000.0 мянган төгрөг, А/364 дүгээр тушаалаар 6,600.0 мянган төгрөг, үл хөдлөх өвийн тооллогын зардал 13,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/42 дугаар захирамжаар 19,608.4 мянган төгрөг, А/259 дүгээр захирамжаар 748.0 мянган төгрөг, А/343 дугаар захирамжаар 26,858.2 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах 15,000.0 мянган төгрөг зэрэг нийт **101,814.6** мянган төгрөгийн орлогууд төвлөрснөөс 91,161.3 мянган төгрөгийг зарцуулж, 10,612.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлэн, 40.6 мянган төгрөгийн мөнгөн кассын үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Албан өрөөний тавилга, эд хогшил худалдан авахад 16,000.0 мянган төгрөг, суурин компьютер худалдан авахад 10,758.0 мянган төгрөг, зөөврийн компьютер авахад 2,500.0 мянган төгрөг, канон худалдан авахад 1,427.8 мянган төгрөг, суурьтай туг худалдан авахад 880.0 мянган төгрөг, цахилгааны утас, залгуур худалдан авахад 275.0 мянган төгрөг зэрэг нийт **31,840.8** мянган төгрөгийг зарцуулсан,
- “Нүүдэлчин Монгол 2022” наадамд гэр болон Улаанбаатар хот руу гэр ачих машины түрээсийн төлбөрт 9,500.0 мянган төгрөг, сумдаас оролцогчдын унааны зардалд 8,884.8 мянган төгрөг, хүнсний материалын зардалд 3,991.0

мянган төгрөг, бусад зардалд 4,442.0 мянган төгрөг зэрэг нийт **26,817.8** мянган төгрөгийг зарцуулсан,

- Үл хөдлөх өв, соёлын дурсгалт газрын тооллого хийх ажлын шатахууны зардалд 6,902.7 мянган төгрөгийг зарцуулсан,
- “Нийтийн номын сангийн баяжилт” ажлын хүрээнд аймгийн Номын санд 9,500.0 мянган төгрөг, 17 сум, 5 тосгоны Соёлын төвд тус бүр 500.0 мянган төгрөг зэрэг нийт **20,500.0** мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон,
- “Соёлын бүтээлч сар”-ын ажлыг зохион байгуулахад Сэлэнгийн долгио болон Мөнгөн хараа чуулга, 15 сумын Соёлын төвд тус бүр 300.0 мянган төгрөг буюу нийт **5,100.0** мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.



Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, урлагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал


Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн нийт зардлын 211,939.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,119.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд тайлант оны батлагдсан төсвөөс дараах зардлуудыг хэмнэсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 28.7 хувь буюу 44,036.1 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 33.1 хувь буюу 7,004.9 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 11.4 хувь буюу 765.9 мянган төгрөгөөр,
- Эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 0.4 хувь буюу 40.4 мянган төгрөгөөр гэх мэт.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих дараах 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны мэдээллийг 2 удаа,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 2 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн мэдээллийг 2 удаа,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг 2 удаа,
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг 2 удаа гэх мэт.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн тул зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Соёл, урлагийн газар нь 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 1369001008 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ авч үйл ажиллагаагаа эхэлсэн тул өмнөх онд аудит хийгдээгүй болно.



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулсан алдаа гараагүй байна.

Аудитаар нийт 19,818.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 157.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,921.4 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 4,739.7 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Тус газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Отгонтуяад албан томилолтоор Улаанбаатар хот руу 2 удаа явсан унааны зардалд 157.0 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүйгээр илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.10 дахь “Унааны зардлын баримтыг төрийн албан хаагч албан томилолтын тайландаа хавсаргах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон унааны зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 290.0 мянган төгрөгийн цалингийн авлага, 2,141.4 мянган төгрөг / НДШ-ийн 114.1 мянган төгрөг, ХХОАТ-ын 633.1 мянган төгрөг, Цахим ертөнц ХХК-д бичиг хэргийн болон бусад бараа материалын 1,394.2 мянган төгрөг/-ийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах зарчмыг алдагдуулж тайлант оны 9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр унаа,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хоолны хөнгөлөлтийн батлагдсан төсөв хэмнэгдэхээр байтал хэмнэлтийг татан төвлөрүүлэхээс зайлсхийж, өдрийн 5.0 мянган төгрөг байсан унаа, хоолны хөнгөлөлтийг газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 20.0 мянган төгрөг болгон 4 дахин нэмэгдүүлж, 10-12 сард нийт **6,990.0** мянган төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2 дахь “Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно.”, 8.4 дэх “Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын **тодорхой хэсгийг** байгууллагаас нөхөн олгоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Анхан шатны баримтын бүрдэлгүй буюу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар дараах ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Эмчилгээ хийлгэснийг нотлох эмнэлгийн байгууллагын магадалгаа буюу анхан шатны баримтгүйгээр тус газрын төсвийн мэргэжилтний албан тушаалыг хавсран гүйцэтгэж буй аймгийн БШУГ-ын мэргэжилтэн П.Золжаргалын аавын эмчилгээнд 500.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/26 дугаар тушаалаар олгосон байна.
- “Нүүдэлчин Монгол 2022” өв соёлын наадмын үйл ажиллагаанд шаардлагатай гэр, бусад эд зүйлсийг Сэлэнгэ-Улаанбаатар-Тэрэлжийн амралт руу зөөвөрлөсөн ачааны машины түрээсийн зардал гэх мэт 5,000.0 мянган төгрөгийг хүчин төгөлдөр бус буюу гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй гэрээг үндэслэн Мандал сумын иргэн н.Алтансүх-д нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр, анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 4,739.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим баримтыг үндэслэн худалдан авалтын ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.


2. Санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна.” 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасны дагуу тайлант оны санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг иж бүрэн хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Томилолтын зардлыг илүү олгосон.	1	157.0	1	157.0									
Авлага, өр төлбөр үүсгэсэн.	1	2,431.4			1	2,431.4							
Төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	6,990.0			1	6,990.0							
Анхан шатны баримтгүй буюу хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	2	5,500.0			2	5,500.0							
Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй.	1	4,739.7					1	4,739.7					
Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй.	1	-					1	-					
Дүн	7	19,818.1	1	157.0	4	14,921.4	2	4,739.7					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	10	-							10	-		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
	-	-										
Нийт дүн	10	-							10	-		